



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 4/296

Мандалговь

Хүүхдэд хамаатай орчинд үзлэг шалгалт  
хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66.1 Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдэд хамаатай орчинд үзлэг шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Болор-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Н.Мөнгөнцэцэг (Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын ЭМБХХХ-ийн дарга, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч)

А.Цэвээнсүрэн (Аймгийн Цагдаагийн газрын Хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Б.Буманбаатар (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ш.Эрдэнэсүвд (Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхэд хамгаалал, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Барилга байгууламжийн замын ажлууд эхэлж байгаатай холбогдуулан хүүхдийн аюулгүй байдал, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор сургууль, цэцэрлэг, сургалтын анги танхим,

4822100484

хүүхдийн тоглоомын талбай, хүүхэд зорчих зам, талбай, хүүхдэд хамаатай орчинд үзлэг шалгалт хийж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хийсэн ажлын тайлан мэдээг Ерөнхийлөгчийн тамгын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэн танилцуулахыг ажлын хэсэг (М.Болор-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ